

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь Бор-Өндөрийн далд уурхайн агаарын урсгал, найрлага, даралтын хэмжилт, судалгааны ажлыг гүйцэтгэж зөвлөмж боловсруулах ажил (гендерийн дугаар *МРЦМ/201901196*)-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет”ТӨҮГ-ын Бор-Өндөрийн далд уурхайн агаарын урсгал, найрлага, даралтын хэмжилт, судалгааны ажлыг гүйцэтгэж зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэж, үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээмжийг өсгөх, аюулгүй ажиллагааг хангах, хүрээлэн буй орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах боломжоор хангахад чиглэгдэнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ.

- ТӨХБАҮХАТухай хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан нотлох баримт
- Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: 2016,2017,2018 (Сүүлийн гурван жилд тухайн чиглэлээр хийж гүйцэтгэсэн зураг төсөл, зөвлөх үйлчилгээний жагсаалт, гэрээний хуулбарыг гэрээ дүгнэсэн актын хамт ирүүлнэ)
- Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийн “Уурхайн малталтуудыг агааржуулах” б□лгийн холбогдох заалтуудын шаардлагыг хангасан эсэхийг хянах, шалгах, хэмжих шаардлагатай багаж, тоног т□х□□р□мж (баталгаажсан)-тэй байх
- Далд уурхайн агаарын даралтын хэмжилт зураглалын ажлын дүнгээр “Х□дрийн далд уурхайн аюул□й байдлын д□рэм”-ийн “Уурхайн малталтуудыг агааржуулах” б□лгийн холбогдох заалтуудын шаардлагыг хангасан эсэхийг магадлах, сайжруулахад чиглэгдсэн з□вл□мж □г□х чадвартай боловсон хүчинтэй байх
- Урьд нь далд уурхайн агаарын даралтын хэмжилт, зураглал хийж байсан ажлын туршлагатай байх

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Гадаадын этгээд оролцох эрхгүй.

5. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө дор дурдсан хаягаар ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ **2019 оны 9 дугаар сарын 2-ний өдрийн 15:00 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn** хаягаар ирүүлнэ.

“Монголросцветмет” ТӨҮГ

Хаяг: Улаанбаатар хот-51, ш/х-002

Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 22-р хороо,

“Монголросцветмет”ТӨҮГ-ийн өөрийн байр, өрөө: 305

И-майл: mailbox@monros.mn

Утас: 453482, 450060-243, факс 458380